

ЎОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН”

Сум хөгжүүлэх сан



Зээлийн хүү	3 хувь
Хугацаа	36 сар хуртгал

Start-Up
Шинээр ЖДҮ
байгуулах

ЖДҮ-ийн үйл ажиллагаагаа
өргөтгөх, шинэчлэх



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД МӨРДӨХ ХУУЛЬ, ЖУРАМ, ЗААВРЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АГУУЛГА

Оаёёага айёоаууу:	Товчилсон үгийн тайлбар	3
Айау-Аёоаё аёгаг дахь Төрийн аоёёоуи аасар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр Утас: 99489309	Үндсэн мэдээлэл	5
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг Утас: 99175677	Дэд зорилт-1: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад мөрдөх хууль, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй байна.	5
Аёёао аудитор Ж.Бүжинханд	1.1 Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг холбогдох хууль эрх зүйг баримтлалгүй төлөвлөж, хуваарилсан байна.	6
Аудитор: Г.Энхдэлгэр М.Атарцэцэг	1.2 ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгээгүй, төсөл, арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэсэн байна.	7
2018 ий 11 дүгээр нөд	1.3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, тайлан мэдээг сумууд ирүүлээгүй тул хэлэлцээгүй байна.	12
Аоёёоуи оаёёагаёё оёёагаёё анооаёёаао иуаё оёаооёёао, анооаёё ааёёао çéё ааёёаё 70483413, 70484055 аоаааоуи ооаа, 70484030 аоаааоуи оаёёаао оаёёёоага оо.	Дэд зорилт-2: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад мөрдөх хууль, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй байна.	13
Оауа: Айау-Аёоаё аёгаа	2.1 Сангийн хөрөнгийг бодит тооцоонд үндэслэн хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй, зээлийн гэрээний дагуу 840 зээлдэгчийн 1,980.1 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүү, торгуулийг төлүүлээгүй байна.	13
Анооагаоо сум Баянхайрхан баг	2.2 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.	19
	2.3 Сумын ИТХ, Засаг даргын үүргийн биелэлт хангалтгүй, орон тооны бус зөвлөлийн хяналт сул, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдаагүй байна.	23
	2.4 СХС-ийн зээлийг төрийн байгууллагаар дамжуулан олгодог явдлыг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн, хугацаандаа байгаа зээлийг арилжааны банкинд шилжүүлэн, цаашид банкаар дамжуулан зээл олгодог болох нь зүйтэй байна.	24
	Дэд зорилт-3: Аудитаар өгөгдсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	25
	3.1 Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг 45.6 хувиар, албан шаардлагыг 99 хувиар, хариуцлага тооцох саналыг 88 хувиар биелүүлсэн байна.	25
	3.2 СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитын шийдвэрийг 65 хувиар хэрэгжүүлсэн байна.	26
	Илрүүлэлт	27
	Аудитын дүгнэлт	31
	Аудитын шийдвэр ба санал болгох зүйлс	31
	Холбогдох байгууллагын санал	33
	Саналын хариу тайлбар	34
	Тэргүүлэх аудиторын тушаал	35
	Хавсралтууд	36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэний нийтийн хурал
МУ	Монгол улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
УАГ	Үндэсний аудитын газар
ХХААЖДҮГ	Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрлэлийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

ХҮСНЭГТЭН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
1	СХС-ийн орлогын судалгаа	14
2	СХС-ийн зарлагын судалгаа	15
3	Говь-Алтай аймгийн СХС-ийн мөнгөн хөрөнгийн нэгдсэн судалгаа	15
4	СХС-ийн зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь	16
5	СХС-ийн хөрөнгөнөөс зээл авсан зээлдэгчийн судалгаа	16
6	СХС-ийн зээл эргэн төлөлт, авлагын судалгаа	17
7	Гэрээний хугацаа хэтэрсэн зээлийн судалгаа	18
8	СХС-ийн аудитаар тогтоосон шийдвэрийн хэрэгжилтийн судалгаа	26
9	Шийдвэрийн хэрэгжилт	26

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Дүрслэлийн нэр	Хуудас
1	Сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт	9
2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт	10
3	СХС-ийн хөрөнгийн орлогын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа	14
4	Зээлийн гэрээний дагуу эргэн төлөлт	17
5	Сангийн зарцуулалтад тавигдах шаардлага	20
6	Хэрэгжүүлээгүй шийдвэрийн эзлэх хувь	26

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл**Аудит хийх үндэслэл үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

ОНХС болон СХС-ийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
2. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
3. Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Хамарсан хүрээ: Аудитаар

- ✓ ОНХС-ийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал
- ✓ СХС-ийн 2017, 2018 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, хяналт, тайлагнал, 2011 оноос 2018 оны хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтийг сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын Засаг дарга, ИНХ, төсөл хэрэгжүүлэгчдийг хамруулан судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймаг, сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

- ✓ ОНХС-ийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний саналын эрэмбэлэлт, орлогын төлөвлөлт, сонгон шалгаруулалт, сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, хяналт, өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэж шалгасан.
- ✓ СХС-ийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, зарцуулалт, сонгон шалгаруулалт, зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээ, зээлдэгчийн хувийн хэргийн бүрдэл, зээлийн эргэн төлөлт, авлага, гэрээний хэрэгжилт, үр өгөөж, хяналт, өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж үзлээ.
- ✓ Мөн ОНХС, СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавигдах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журмын хоорондын нийцэл, бусад хууль тогтоомжтой зөрчигдөж байгаа эсэхийг шалгаж цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн асуудал байгаа эсэхийг судаллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”.
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдсэн. Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө. Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Г.Энхдэлгэр, М.Атарцэцэг нар 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аóàèò òèèòýä ó÷èðñàí áýðòòýý

Аудит хийх хугацаанд ҮАГ-ын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу “2018 оны төсвийн хуулийн хэрэгжилтийн явц” санхүүгийн аудитыг давхар гүйцэтгэж байсан тул ажлын ачаалал маш их байлаа. Сумдад 2-3 хоногийн хугацаанд аудит хийгдсэн учир сумын төвд байхгүй төсөл хэрэгжүүлэгч нартай уулзах боломжгүй байсан. Есөнбулаг сумын зээлдэгч нарын үйл ажиллагаатай газар дээр нь танилцахад төсөл хэрэгжүүлэгч нар байхгүй хариуцсан ажилтан нь зээлдэгчийн талаар мэдээлэлгүй, холбоо барих боломжгүй болсон тул үйл ажиллагааг бүрэн үзэж чадаагүй болно. Мөн аймгийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэнгүй байгаа нь аудит хийхэд хүндрэлтэй байлаа.

Дэд зорилт-1: ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад мөрдөх хууль, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй байна.

ЗОРИЛГО

- Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор сууршилтай амьдрах орчин бүрдүүлэхэд оршдог.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын хувьд 1 дүгээр гарын үсгийг сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч нар нь зурж гүйлгээ хийж байна. Харин Алтай, Шарга сумын хувьд санхүүгийн албаны дарга, аймгийн ОНХС-ийн хувьд төсвийн ерөнхий нягтлан бодогч нар 2 дугаар гарын үсэг зурж гүйлгээ хийж байгаа нь Төрийн сангийн хяналтын чиг үүрэг алдагдаж байна./ОНХС-Хавсралт-1/

1.1 ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан уу?

1.1 Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг холбогдох хууль эрх зүйг баримтлалгүй төлөвлөж, хуваарилсан байна.

1.1.1 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох шилжүүлгийг холбогдох хууль эрх зүй, журам зааврыг мөрдөөгүй төлөвлөж хуваарилсан байна.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХС болон улсын төсвөөс Говь-Алтай аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 2,185.0 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 603.2 сая төгрөгөөр баталжээ.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлж, ОНХС-ийн хуваарилсан хөрөнгийн тодорхой хувийг урамшуулах замаар олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс 2017 онд Баян-Уул, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Хөхморьт, Цогт, Чандмань, Шарга, Эрдэнэ сумын ОНХС-д 361.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.1¹, 59.2.2², 60 дугаар зүйлийн 60.5³, 60.6⁴ дахь заалтуудад ОНХС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг сумын ОНХС-д хуваарилахаар хуульчилжээ.

ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу аймаг нь орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахаар төлөвлөх бөгөөд орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн 4 төрлийн итгэлцүүрт үндэслэн тооцоолохоор байна.

ЗГ-ын 2014 оны 242 дугаар тогтоолоор “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг баталсан бөгөөд 2 жил тутамд нэг удаа тооцож байхыг Эдийн засгийн хөгжлийн яамд даалгасан ч тухайн яам татан буугдаж уг индексийг 2017 онд шинэчлэн тооцож зарлаагүй байна.

ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор итгэлцүүрт ашиглах сумын хөгжлийн индексийг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан сумын хөгжлийн индекс тооцох нийтлэг арга зүйн дагуу өөрийн аймаг, нийслэлийн хөгжлийн онцлог, тоон мэдээллийн боломжид нийцүүлэн тооцож, гаргахаар журамлагдсан. Гэвч Говь-Алтай аймгийн тухайд сумын

¹ энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

² 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

³ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

⁴ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

хөгжлийн индексийг тооцож гаргаагүй, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг төлөвлөж хуваарилсан баримт материал байхгүй байлаа.

Сумдын ОНХС-ийн батлагдсан төсвийг үзэхэд Бигэр, Тайшир, Тонхил, Халиун, Цээл сумдад аймгийн ОНХС-ийн олгох шилжүүлгийг төлөвлөж хуваарилаагүй байгаа нь Төсвийн тухай хууль болон ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолыг мөрдөөгүйг харуулж байна. Иймд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөж хуваарилахдаа холбогдох хууль эрх зүйг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтад заасны дагуу сумын Засаг дарга ОНХС-ийн эх үүсвэрийг аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг, сумын үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж гэсэн эх үүсвэрээр төлөвлөхөөр байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг батлахдаа ОНХС-аас 2,185.0 сая төгрөгийн санхүүжилт, шилжих үлдэгдлээс 1,394.9 сая төгрөгийг, орон нутгийн орлогоос 179.6 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 50.5 сая төгрөгийг нийт 3,810.2 сая төгрөгийг ОНХС-д оруулахаар тооцож баталжээ.

Алтай, Төгрөг, Цогт, Есөнбулаг сумд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох орлогыг, Алтай, Бигэр сумд хандив тусламжийн орлогыг төлөвлөсөн байна. Аймаг болон бусад 14 сумдын тухайд орлого нэмэгдүүлэх санаачлага гаргаагүй байна.

Цогт сум нь ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 25.5 сая төгрөгийг ОНХС-д төлөвлөж хуваарилсан байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журмыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ. /ОНХС-хавсралт-2/

1.1.3 ОНХС-аас төлөвлөсөн орлогын шилжүүлгийг бүрэн авч, сумд олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгожээ.

ОНХС-аас аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 2,185.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөн санхүүжилтээ бүрэн авсан байна. Мөн Баян-Уул, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Хөхморьт, Цогт, Чандмань, Шарга, Эрдэнэ сумын ОНХС-д улсаас 361.1 сая төгрөгийн урамшуулал олгосон. Аймгийн ОНХС-аас Жаргалан сумын батлагдсан төсвөөс 0.1 сая төгрөгийг дутуу санхүүжүүлснийг эс тооцвол Алтай, Бугат, Дарив, Жаргалан сумд 90.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг төлөвлөсний дагуу олгожээ.

1.2 ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгээгүй, төсөл, арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэсэн байна.

1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр 3,810.2 сая төгрөгийн 169 багц төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3⁵-т зааснаар Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримталсан эсэх, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөсөн эсэх, хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын

⁵ Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараахь зүйлсийг баримтална:

үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй эсэх, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан эсэх, иргэдийн оролцоог хангасан байдал зэргийг судаллаа.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сум дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна. Харин Цээл сум нь Хөх энгэр, Авдран, Хажуу булаг, Хүүш, Жаргалантын эхний бэлчрийн зам давааг засварлах ажил, ахуйн үйлчилгээний засвар, малжуулах зэрэг 21.3 сая төгрөгийн 6 төрлийн ажлууд нь сумын 2012-2020 оны эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Санал эрэмбэлэлт

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний саналын хуудас, эрэмбэлэлт, сумын ИТХ-д өргөн барьсан баримт материалыг үзэхэд дараах асуудалтай байна. Тухайлбал:

- Бигэр, Дарив, Дэлгэр, Халиун, Цогт, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг сумын ИНХ-р хэлэлцүүлж баталсан баримт байхгүй.
- Бугат, Дэлгэр сумын иргэдээс авсан санал асуулгын хуудас нь батлагдсан маягтаар өгөгдөөгүй, санал өгсөн хүний овог нэр, гарын үсэг зурж баталгаажуулаагүй, эрэмбэлсэн баримт материал байхгүй, багийн ИНХ-ийн тогтоол нь батлагдсан тэмдэглэлийн маягтын дагуу хөтлөөгүй, оролцогчийн мэдээлэл тодорхойгүй, хуралд оролцогчдын гарын үсгээр баталгаажуулаагүй байна.
- Бугат, Дарив Жаргалан, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт сумууд санал эрэмбэлэлт хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилоогүй, сумын ИТХ-д хэрэгжүүлэх ажлын тоо төсвийн төслийг өргөн барьсан баримт материал байхгүй байлаа.

Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Халиун, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сум нь иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 32 төсөл арга хэмжээнд 369.8 сая төгрөгийн төсвийг сумын ИТХ-аар баталсан. /ОНХС-хавсралт-3/

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, төсвийн тооцоолол

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 3,167.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 117 ажлыг ИТХ-аар баталсан. Үүнд:

- Аймгийн ОНХС нь 2,272.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй байхад ИТХ-аар төсөв тавьж баталсан.
- Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд нь 895.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 79 төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй байхад ИТХ-аар төсөв тавьж баталжээ. /ОНХС-хавсралт-4/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶ дэх заалтад хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар заасныг зөрчсөн байна. Мөн ОНХС-ийн заавар, Төсвийн төсөл боловсруулах журмыг зөрчжээ.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжийг баримтлан, хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг сайжруулахаар байна.

Сонгон шалгаруулалт

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлсэн 222 төсөл арга хэмжээний 5.4 хувь буюу 12 ажлыг нээлттэй тендер, 15.3 хувь буюу 34 ажлыг харьцуулалтын аргаар, 74.7 хувь буюу 166 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

байгуулжээ. Харин Дэлгэр, Цогт, Чандмань, Эрдэнэ сумууд нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр 147.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 ажлыг шууд гэрээ байгуулсан.

Мөн Дэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх өөрөө буулгагч хог тээврийн машин нийлүүлэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулан "Хөв дэлгэр" хоршоог шалгаруулсан байтал уг хоршоотой гэрээ байгуулахаас үндэслэлгүй татгалзаж, "Эй Ди Өү" ХХК-тай 15.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан нийт 46 төсөл арга хэмжээнээс 30.4 хувь буюу 14 төсөл арга хэмжээ нь тендерт материал ирээгүй, тендерт тэнцээгүй шалтгаанаар шууд гэрээ байгуулах зөвлөмж гарсан байна. /ОНХС-хавсралт-5/

Захиалагчийн хяналт

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн буюу гэрээ байгуулан санхүүжилт олгосон 3,884.2 сая төгрөгийн 233 төсөл арга хэмжээнээс 207.7 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй байна. /ОНХС-хавсралт-6/ Тухайлбал:

- Алтай сум 38.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ, Жаргалан сум 43.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ, Халиун сум 12.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ, Цогт сум 67.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл арга хэмжээ, 45.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй байна.

Захиалагчийн хяналтыг тавихад мэргэжлийн чадвар дутмаг, зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмжгүй зэрэг шалтгаанаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чадахгүй байгаа төсөл арга хэмжээ үр дүнгүй хэрэгжихэд хүргэх эрсдэлтэй юм.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт:

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр сумын хэмжээнд 233 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 3,884.2 сая төгрөгийн гэрээ байгуулан 3,590.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4 дахь хуулийн заалтаар сумын 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг багцалж дараах дүрслэлээр харууллаа.

Дүрслэл-1



Хуульд заагаагүй төсөл арга хэмжээнд зориулалт бусаар 210.7 сая төгрөгийг зарцуулсан ажлын тухайд Халиун, Жаргалан, Хөхморьт сумд ОНХС-ийн хөрөнгөнөөс гамшгаас хамгаалах иргэний хамгаалалтын хувцас хэрэгсэл бэлтгэсэн, Бугат сум улсын төсөвт байгууллага болох УЦУОШГ-ын барилгын засварын ажил хийсэн, Цогт сум сурагчдаас шалгалт зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, Эрдэнэ сум хувийн байгууллага болох Жи мобайлын сүлжээ оруулах

ажлыг хийсэн байна. /ОНХС-хавсралт-7/

- Аймгийн ОНХС-ийн тухайд:
- ✓ Алтай радио, Гэгээн нуур цэвэр ус ОНӨААТҮГ-т 101.6 сая төгрөгийн урсгал санхүүжилтийн дэмжлэг олгосон.
 - ✓ Улсын төсөвт байгууллага болох Нэгдсэн эмнэлэг, Баян-Уул сумын сум дундын эмнэлэг, УЦУОШГ-т 71.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
 - ✓ Айл өрхийн хувийн өмчлөлд 146.7 сая төгрөгийн хогийн пункер, дулаан баригч зуухыг олгосон.
 - ✓ Хөтөлбөр арга хэмжээний хүрээнд 179.1 сая төгрөгийн урсгал зардалд зарцуулсан.

Дүрслэл-2



/ОНХС-хавсралт-8/

Аудитаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийг үзэхэд:

- ✓ Төгрөг, Халиун, Есөнбулаг сум нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын батлагдсан төсвийг 4.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
- ✓ Халиун сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 25.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ундны цэвэр усаар хангах худаг гаргах ажлыг гэрээний хугацаа хэтрүүлэн хүлээлгэн өгсөн.
- ✓ Халиун, Цээл, Шарга, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 267.7 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан боловч төсөл хэрэгжүүлэгч хүлээлгэж өгөөгүй.
- ✓ Халиун, Цогт, Чандмань, Есөнбулаг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 64.5 сая төгрөгийн 14 ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан баримт материал байхгүй.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг бодит байдалд үзэж танилцахад:

- ✓ Алтай сумын 3.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Соёлын төвийн барилгын дээврийн засварын ажил хангалгүй хийсэн, Цогт сумын соёл амралтын талбайн хайсны суурь, явган зам спортын талбайн тохижилтын ажлыг дутуу гүйцэтгэсэн байхад хүлээж авсан.
 - ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Солонго хорооллын 3.8 км хатуу хучилттай авто замын гэрэлтүүлэг, Алтай хотын тохижилтын ажлаар хийгдсэн гэрэлт цамхгийн цахилгааны төлбөрийн төлөх төсвийн асуудал шийдэгдээгүй тул асаахгүй байна.
 - ✓ Есөнбулаг сумын Баянхайрхан, Баяншанд, Жаргалант, Харзат багуудад тавьсан интернэтийн тоног төхөөрөмж суулгасан боловч цахилгааны асуудлаас ажиллуулаагүй байна.
 - ✓ Аймгийн ОНХС-аас хог тээврийн автомашины мотор эвдэрсэн ашиглалтгүй байна.
- ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний баримт материалтай танилцахад:
- ✓ Халиун сум нь гамшгаас хамгаалах ажлын шатахуунд зарцуулсан 1.0 сая төгрөгийн, Чандмань сум нь 5.0 сая төгрөгийн баяр наадмын зардлын, Эрдэнэ сум айл өрхийн хог тээвэрт зарцуулсан 4.7 сая төгрөгийн анхан шатны баримт материал байхгүй байна.

- ✓ Цогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 68.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 ажлын тухайд гүйцэтгэгчийн хийсэн ажлын тайлан гаргаж өгөөгүй, анхан шатны нотлох баримтгүй байхад санхүүжилтийг олгосон.

Өмнөх оны хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл үр дүн

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2018 оны хооронд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрөөс өвсний нөөц бүрдүүлэлт, малжуулалт, хөрөнгийн ашиглалтыг үзлээ.

Өвсний нөөц бүрдүүлэлт:

Аудитаар тус онуудад 120.3 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөцөд хөрөнгө зарцуулсан байгаа бөгөөд өвс тэжээлийн тооцоог тулган шалгахад өвс тэжээлийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй, авлагаар тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулсан актгүй данснаас гадуур зарж мөнгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрч байна. Тухайлбал:

- ✓ Бигэр сум 9.5 сая, Дэлгэр сум 8.3 сая, Цогт сум 5.0 сая, Халиун сум 1.7 сая, Төгрөг сум 20.9 сая, Хөхморьт сум 13.8 сая, Чандмань сум 1.5 сая, Есөнбулаг сум 2.8 сая төгрөгийн өвс тэжээлийн мөнгийг төвлөрүүлээгүй байна.

Бигэр сумд тооллого хийхэд иргэдээс 8.8 сая төгрөгийн өвс тэжээлийн авлагатай, “Бигэр буудай” хоршоо 4.5 сая төгрөгийн тэжээлийг дутуу нийлүүлсэн, 2018 онд бэлнээр борлуулсан өвс тэжээлээс 6.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй, нийт 19.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. “2018 оны Төсвийн хуулийн хэрэгжилтийн явц”-ын аудитаар Гамшгаас хамгаалах сангийн эх үүсвэрийн 10.0 сая төгрөгийн дүнд төлбөрийн акт тогтоосон. Сумдын ОНХС-ийн хөрөнгөнөөс зарцуулсан өвс тэжээлийн нөөцийн 45.9 хувь буюу 52.5 сая төгрөгийг төвлөрөөгүй байгаа нь холбогдох албан тушаалтан ажлын хариуцлагагүй төсөв үр ашиггүй зарцуулагдаж байгааг харуулж байна. /ОНХС-хавсралт-9/

Тонхил сум нь “Өндөр Индэр” хоршоотой байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад 4.0 сая төгрөгийн өвс тэжээлийн мөнгийг төлүүлээгүй бөгөөд гэрээний дагуу 2.0 сая төгрөгийн алданги нэмж ногдуулсан.

Хөхморьт сумын ЗДТГ-ын агуулахад их хэмжээний задарсан өвсний үлдэгдэл байгаа бөгөөд өвс борлуулах ажилд хяналт тавьж ажиллаагүй байна.

Малжуулалт:

ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2017 оны хооронд аймгийн хэмжээнд нийт 1,035.3 сая төгрөгийн малжуулалт хийгдсэн байна. Аудитаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2014 онд Монгол мал хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан 136.0 сая төгрөгийн хэрэгжилтийг үзээгүй болно.

Малчидтай хийсэн гэрээний хугацаа дууссан байхад Алтай сум 13 өрхөд олгосон 51.0 сая төгрөгийн үнэ бүхий 291 толгой бог малыг, Бигэр сум 5 өрхөд олгосон 30.0 сая төгрөгийн 52 толгой бод малыг, Төгрөг сум 80 өрхөд олгосон 22.9 сая төгрөгийн 16 толгой бод малыг, 480 толгой бог малыг, Хөхморьт сум 118 өрхөд олгосон 174.5 сая төгрөгийн 1770 бог малыг, Цогт сум 143.5 сая төгрөгийн 49 өрхөд олгосон 146 толгой бод малыг гэрээний хугацаа дууссан дараагийн өрхөд шилжүүлээгүй байна.

Мөн малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор малчдад 107.8 сая төгрөгийн хээлтүүлэгч малыг олгосон. Үүнээс Баян-Уул сум 5.0 сая төгрөгийн 41 толгой мал, Төгрөг сум 6.5 сая төгрөгийн 80 толгой мал, Есөнбулаг сум 15.0 сая төгрөгийн 70 толгой малыг гэрээний хугацаа дууссан байхад хүлээж аваагүй байна. /ОНХС-хавсралт-10 а, б/

Хөрөнгийн ашиглалт

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн үр өгөөжийг үзэхэд 235.6 сая төгрөгийн 22 ажлын чанар байдал муу, ашиглалт хангалтгүй байна. Мөн сумын ОНХС-аас 76.3 сая төгрөгийн өртөг бүхий 6 ажилд 51.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч бүрэн хэрэгжээгүй ажлууд байна. Үүнд:

- ✓ Жаргалан сумд 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “0.4 шугамын өргөтгөл”-ийн ажлыг 19.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 7.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч одоог хүртэл огт хийгдээгүй, захиалагч тал хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлэх талаар ажиллаагүй байна.

- ✓ Халиун сумд 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Өвс тэжээлийн цэг барих” ажлыг 4.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон боловч одоог хүртэл огт хийгдээгүй байна. Сумын ЗДТГ нь гүйцэтгэгч байгууллагыг Шүүхэд өгсөн байна.
- ✓ Бугат сумд 2013 онд хэрэгжсэн “Гудамжны гэрэлтүүлэг”, Тонхил сумд 2016 онд хэрэгжүүлсэн “Мал угаалгын ванн”, Халиун сумд 2015 онд хэрэгжүүлсэн “Ёслол хүндэтгэлийн өргөөний засвар”, Хөхморьт сумд 2014 онд хэрэгжүүлсэн “Нэрэмжит талбай байгуулах” ажлуудыг хүлээлгэж өгөөгүй, дутуу хэрэгжсэн байна.

Бүртгэл тайлагнал

ОНХС-ийн хөрөнгөөр шинээр 2017 онд 3,624.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 222 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс бүрэн хүлээж авсан 1,788.7 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тайлагнахаар байна. Алтай сумд 36.8 сая төгрөгийн “Зип кабельжуулах”, Баян-Уул сумд 43.5 сая төгрөгийн “Бөхийн өргөөний засвар”, Төгрөг сумд 7.0 сая төгрөгийн “Өвс тэжээл”, Халиун сумд 2.9 сая төгрөгийн “Өвс тэжээл”, Цогт сумд 46.4 сая төгрөгийн Цэмцгэр Цогт-Соёл амралтын талбайн хайсны суурь, явган зам, спортын талбайн тохижилт, “Нийтийн эзэмшлийн соёл амралтын талбайн хайс, хаалга, талбайн гэрэлтүүлэг, сандал”, “Цэмцгэр цогт-Сумын хаалга”, “Халуун усны насос”, Цээл сумд 3.8 сая төгрөгийн “Малжуулалт” зэрэг сангаас хийсэн хөрөнгийг бүртгээгүй байна. /ОНХС-хавсралт-11/

1.3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг “ОНХС-ийн заавар”-ын дагуу тайлагнасан уу?

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, тайлан мэдээг сумууд ирүүлээгүй тул хэлэлцээгүй байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн буюу гэрээ байгуулан санхүүжилт олгосон 3,884.2 сая төгрөгийн 233 төсөл арга хэмжээнээс Алтай, Жаргалан, Халиун, Цогт, Эрдэнэ сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 197.1 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээнд сумдын ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй байна. /ОНХС-хавсралт-6/

Аймгийн ИТХ-аас ОНХС-аас хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг байгуулан ажилласан. Иргэд олон нийт иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын байдалд хяналт хийгээгүй, албан ёсны хяналт хийгдсэн нотлох баримтгүй байна. Мөн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ОНХС-ийн үйл ажиллагаанд 2017 онд хяналт хийгдээгүй байна.

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст 18 сум ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг ирүүлсэн, жилийн эцсийн тайланг ирүүлээгүй байна. Аймаг нь ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийг Сангийн яамны ОНХС-ийн хэлтэст хүргүүлээгүй. Аймгийн Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг томилоогүй, аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс нь дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь “ОНХС-ийн заавар”-ын 10 дахь заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

Шилэн дансны тухай хууль”-д заасан аймгийн ОНХС, сумын ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний мэдээллийг аймаг, сумууд мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудаст байршуулж иргэдэд танилцуулсан байна.

1.4 ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журмын хоорондын нийцэл, бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх, сангийн үйл ажиллагаа нь зорилго зорилтдоо хүрсэн эсэх, цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн асуудал байна уу?

ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын тушаалаар 2018 онд шинэчлэн баталсан байна. Аудитаар хууль тогтоомжтой холбоотой санал байхгүй болно.

Дэд зорилт-2: СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад мөрдөх хууль, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

СХС-ийн хувьд ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмыг баталж мөрдөж байна. Уг тогтоолоор ЗГ-ын 2011 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” 134 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцжээ.

СХС-ийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан.

СХС-ийн хөрөнгийн зарцуулалтын хувьд 1 дүгээр гарын үсгийг сумдын Засаг дарга, 2 дугаар гарын үсгийг Алтай, Дэлгэр, Жаргалан, Цээл сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн, Есөнбулаг сумын санхүүгийн албаны дарга, бусад сумдын хувьд нягтлан бодогч нар нь зурж гүйлгээ хийж байна. Есөнбулаг сумын хувьд санхүүгийн албаны дарга гарын үсэг зурж гүйлгээ хийж байгаа нь Төрийн сангийн хяналтын чиг үүрэг алдагдаж байна. /Хавсралт-1/

2.1. СХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан уу?

2.1 Сангийн хөрөнгийг бодит тооцоонд үндэслэн хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй, зээлийн гэрээний дагуу 840 зээлдэгчийн 1,980.1 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүү, торгуулийг төлүүлээгүй байна.

2.1.1 СХС-ийн хөрөнгийг бодит тооцоонд үндэслэн хууль, журамд заасны дагуу төлөвлөхөөр байна.

СХС-ийн хөрөнгийн эх үүсвэр нь улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив тусламж, сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги зэргээс бүрдэж байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт, тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3.1-д сумын ИТХ нь жил бүр СХС-ийн төсвийг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн сангийн зарлагын эх үүсвэрийг төлөвлөхдөө Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт, тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.8⁷, 3 дугаар зүйлийн 3.5.7⁸ дахь заалтын дагуу зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад зарцуулах дүнг

Сангийн бүрдүүлэлтийн систем



⁷ Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

⁸ Сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт ИТХ-аар батлуулах

хүүгийн орлогын 30 хувиар, хяналтын зардалд зарцуулах дүнг хүүгийн орлогын 20 хувиар тооцож тус тус төлөвлөхөөр байна.

Аудитаар сумдын 2017, 2018 оны төсөв баталсан ИТХ-ын тогтоол, аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2018 оны төсвийн төлөвлөгөөг үндэслэн СХС-ийн төсвийн орлого зардлын төлөвлөгөөний харьцуулсан судалгааг хийлээ.

Хүснэгт-1

Сангийн орлогын төлөвлөлт /сая.төг/

Үзүүлэлт	2017 он			2018 он		
	Төлөвлөгөө /ИТХ/	Төлөвлөгөө /ТЕЗ/	Төлөвлөвөл зохих	Төлөвлөгөө /ИТХ/	Төлөвлөгөө /ТЕЗ/	Төлөвлөвөл зохих
СХС-ийн өмнөх оны үлдэгдэл	314.3	388.5	388.5	178.0	1,297.2	1,297.2
Үндсэн зээлийн эргэн төлөлт	1,099.8	1,165.1	2,783.9	1,159.0	175.0	2,868.2
Зээлийн хүүгийн орлого	10.34	59.53	111.37	9.75	-	100.18
Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги, торгууль	-	-	104.3	-	-	136.1
Нийт дүн	1,424.4	1,613.1	3,388.1	1,346.8	1,472.2	4,401.7

Дүрслэл.3 СХС-ийн хөрөнгийн орлогын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа



Дээрх судалгаанаас үзэхэд сумдын ИТХ-аар баталсан СХС-ийн хөрөнгийн төсөв нь орон нутгийн нэгдсэн төсвийн СХС-ийн төлөвлөлтөөс 2017 онд 240.7 сая төгрөгөөр, 2018 онд 456.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Үүнд:

- СХС-ийн хөрөнгийн орлогыг төлөвлөхдөө үндсэн зээл, хүүгийн орлогыг салгаж төлөвлөөгүй тул зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, хяналтын зардал төлөвлөх боломжгүй болсон.
- Алтай, Бугат, Дэлгэр, Төгрөг сумдын ИТХ-ын тогтоолоор СХС-ийн орлогын эх үүсвэрийг батлаагүй байхад 2017 онд 214.7 сая төгрөгийн, 2018 онд 290.7 сая төгрөгийн төсвийг орон нутгийн нэгдсэн төсвийн СХС-ийн төлөвлөгөөнд оруулж тайлагнасан.
- Бигэр, Жаргалан, Халиун, Цээл, Эрдэнэ сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан СХС-ийн орлогын эх үүсвэрээс 2017 онд 25.9 сая төгрөг, 2018 онд 165.3 сая төгрөгийг орон нутгийн нэгдсэн төсвийн СХС-ийн төлөвлөгөөнд дутуу оруулсан.

Мөн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө өмнөх оны үндсэн зээл, хүү, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги, торгуулийн төлөгдөөгүй үлдэгдлийг тооцож төлөвлөдөггүй. Тухайлбал 2018 оны тухайд орон нутгийн төсвийн нэгдсэн тайланд СХС-ийн орлогын эх үүсвэрт зээлийн эргэн төлөлтийг төлөвлөөгүй байна. Аудитаар 2017, 2018 оны СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөвөл зохих дүнг тооцож үзэхэд 2017 онд 1,987.2 сая төгрөгийн, 2018 онд 2,975.5 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг дутуу төлөвлөжээ. /Хавсралт-2/

Хүснэгт-2

Сангийн зардлын төлөвлөлт /сая.төг/

Үзүүлэлт	2017 он				2018 он			
	төлөвлөгөө /ИТХ/	Төлөвлөгөө /ГЕЗ/	журмаар тооцоолсон	гүйцэтгэл	төлөвлөгөө /ИТХ/	Төлөвлөгөө /ГЕЗ/	журмаар тооцоолсон	гүйцэтгэл
Зээл олгох	1,402.1	1,606.1	-	1,141.6	1,303.8	1,472.2		633.1
Сургалтын зардал	0.9	-	3.1	-	1.8	-	2.9	-
Хяналтын зардал	6.1	7.0	11.9	4.5	10.9	-	-	0.8
Нийт дүн	1,409.1	1,613.1	15.0	1,146.1	1,316.4	1,472.2	2.9	633.8

Сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан төсвийн орлогын дүн зардлын дүнгээс 2017 онд 15.3 сая төгрөгөөр, 2018 онд 30.4 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Цээл сумын СХС-ийн төлөвлөлт зөрүүтэй байгаагаас шалтгаалсан байна.

Төлөвлөсөн хүүгийн орлогын 30 хувиар зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад зарцуулах дүнг тооцож батлагдсан зардлын дүнтэй харьцуулан үзэхэд Бигэр, Тонхил, Халиун, Цээл, Чандмань сумууд 2017 онд 3.0 сая төгрөгөөр, 2018 онд 1.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн бол Жаргалан сум 2017 онд 0.9 сая төгрөгийг Дэлгэр сум 2018 онд 0.5 сая төгрөгийг илүү төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн хүүгийн орлогын 20 хувиар хяналтын зардлын дүнг тооцож батлагдсан зардлын дүнтэй харьцуулан үзэхэд Баян-Уул, Бигэр, Дарив, Дэлгэр, Тайшир, Төгрөг, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ сумууд 2017 онд 8.8 сая төгрөгийн хяналтын зардлыг дутуу төлөвлөсөн бол Алтай, Жаргалан, Чандмань, Шарга, Есөнбулаг сум нь 2017 онд 3.9 сая төгрөгийг илүү төлөвлөжээ.

Мөн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих зардлын гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулан үзэхэд Дэлгэр, Тайшир, Цээл, Шарга, Есөнбулаг сумууд нь зардлын төсөв батлаагүй байхад 2018 онд 0.8 сая төгрөгийг зарцуулсан байна. /Хавсралт-3/

2.1.2 Аймгийн хэмжээнд зээлийн гэрээний хугацаа дууссан 541 зээлдэгчийн 1,680.9 сая төгрөг, гэрээт хугацаандаа байгаа 299 зээлдэгчийн 291.2 сая төгрөг, нийт 1,980.1 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүү, торгуулийг төлүүлээгүй байна.

Мөнгөн хөрөнгө

Сангийн харилцахын гүйлгээг 2011 оноос 2018 оныг хамруулан сум тус бүрээр тооцож СХС-ийн мөнгөн хөрөнгийн нэгдсэн судалгааг гаргалаа.

Хүснэгт-3 Говь-Алтай аймгийн СХС-ийн мөнгөн хөрөнгийн нэгдсэн судалгаа /сая.төгрөг/

Үзүүлэлт	Огноо								Нийт дүн	
	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 оны		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	20.3	189.0	1,221.9	161.5	692.1	523.1	642.6	530.8	20.3	
Орлогын эх үүсвэр	Улсын төсвөөс олгосон сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө	1,130.0	1,155.0	1,135.0	364.8	-	-	-	-	3,784.8
	Төлөгдсөн үндсэн зээл	15.7	149.1	488.3	1,183.4	996.7	883.5	930.0	807.8	5,454.6
	Төлөгдсөн хүүгийн орлого	8.5	20.2	66.4	71.1	58.9	49.1	63.9	50.1	388.3
	Төлөгдсөн алданги, торгууль	-	0.1	0.0	2.9	7.7	7.2	32.5	31.8	82.1
	Данс андуурсан орлого, илүү төлөлт /өглөг/	-	-	24.5	0.2	-	0.4	0.5	3.9	29.5
	Дансаар дамжсан гүйлгээ	124.7	70.1	51.6	128.4	29.0	3.4	8.9	1.6	417.8
Нийт орлогын дүн	1,278.9	1,394.5	1,765.9	1,750.8	1,092.3	943.6	1,035.8	895.3	10,157.2	
Хөрөнгийн зарцуулалт	Олгосон зээл	1,039.6	301.2	2,704.6	1,129.2	1,222.9	788.5	1,141.6	633.1	8,960.6
	Урамшуулал	-	-	1.8	0.9	3.0	2.8	1.5	0.1	10.1
	Хяналт болон үйл ажиллагааны зардал	0.2	2.0	5.3	7.1	8.7	4.6	4.5	0.8	33.0
	Дансаар дамжсан гүйлгээ	70.5	58.5	114.8	83.0	26.7	28.3	-	0.5	382.3
	Нийт зарлагын дүн	1,110.2	361.7	2,826.4	1,220.1	1,261.3	824.1	1,147.6	634.5	9,385.9
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189.0	1,221.9	161.5	692.1	523.1	642.6	530.8	791.6	791.6	

СХС-ийн 2011 оны эхний үлдэгдэл 20.3 сая төгрөг, 2011-2018 онуудад 10,157.2 сая төгрөгийн орлого орсноос 37.2 хувь буюу 3,784.8 сая төгрөг нь улсын төсвөөс СХС-д олгосон шилжүүлэг, 58.3 хувь буюу 5,925.0 сая төгрөг нь зээл, зээлийн хүү, торгуулийн эргэн төлөлт, 4.5 хувь буюу 447.3 сая төгрөг нь зээлдэгчийн илүү төлөлт болон данс андуурсан, данс

дамжсан орлого төвлөрсөн байна. Хөрөнгийн зарцуулалтын хувьд 8,960.6 сая төгрөгийг зээлд олгон, 43.1 сая төгрөгийг сангийн үйл ажиллагаанд зарцуулж, 382.3 сая төгрөгийг дансаар дамжуулан 791.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. /Хавсралт-4/

Зээл олголт, нийт авлага

СХС-ийн хөрөнгөнөөс 2011 оноос хойш бэлэн мөнгөөр 8,960.6 сая төгрөгийн, өглөгөөр 6.6 сая төгрөгийн, ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжөөр 64.0 сая төгрөгийн, байр түрээсээр 19.2 сая төгрөгийн, нийт 9,050.5 сая төгрөгийн зээлийг 1663 иргэн, хоршоо, ААНБ-д олгон 489.5 сая төгрөгийн хүүг төлүүлэхээр зээлийн гэрээ байгуулжээ.

Хүснэгт-4 **СХС-ийн зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь** /сая.төгрөг/

Үзүүлэлт		Огноо											Нийт дүн		
		2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 оны аудитаар	2018 оны аудитын дараах	2019 он	2020 он		2021 он	
Олгосон зээлийн хэмжээ	мөнгөөр олгосон	1,039.6	301.2	2,704.6	1,129.2	1,222.9	788.5	1,141.6	633.1						8,960.6
	Дутуу олгосон мөнгө								6.6						6.6
	Ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжөөр олгосон					31.6	7.0	18.5	7.0						64.1
	Байр түрээс							19.2							19.2
	нийт олгосон зээл	1,039.6	301.2	2,704.6	1,129.2	1,273.8	795.4	1,160.1	646.7	-	-	-	-	-	9,050.5
	Зээлдэгчийн тоо	138	99	545	155	233	177	213	103						1,663
Гэрээний дагуу эргэн төлөгдөх хуваарь	Төлөгдөх үндсэн зээл	19.1	259.5	628.7	1,500.6	1,464.9	1,419.5	1,164.4	849.5	164.8	779.2	630.8	169.5	9,050.5	
	Төлөгдөх хүү	5.2	30.7	61.2	84.4	75.7	66.1	62.3	42.1	10.6	34.8	14.2	2.1	489.5	
Бусад орлого	Дуусгавар болсон гэрээний хүлээн зөвшөөрсөн орлого								4.8					4.8	
Гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцсон торгууль	үйл ажиллагаа явуулаагүйд тооцсон торгуулийн хүү								11.1					11.1	
	Нэмэгдүүлсэн хүү								0.1					0.1	
	Гэрээт хугацаанд төлөгдөөгүй үндсэн зээлийн үлдэгдэлд тооцсон торгууль		1.0		38.7	52.4	64.2	60.5	39.7					256.5	
Нийт төлөгдөх дүн		24.3	291.2	690.0	1,623.7	1,593.1	1,549.9	1,287.2	947.2	175.4	814.0	645.0	171.6	9,812.4	

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах болон гүйцэтгэл, нийцлийн аудитаар зээлийн зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй зээлдэгчид 11.2 сая төгрөгийн торгуулийн болон нэмэгдүүлсэн хүү, гэрээт хугацаанд эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлээ төлөөгүй, эсхүл гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдэд 256.5 сая төгрөгийн торгууль, алдангийг гэрээний дагуу нэмж төлбөрийн акт тогтоосон. Мөн зээлээ бүрэн төлж дууссан зээлдэгч нарын илүү төлсөн 4.7 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн байна. Тус онуудад нийт 9,812.4 сая төгрөгийг СХС-ийн дансанд төвлөрүүлэхээр байна.

Хүснэгт-5 **Зээлдэгчдийн судалгаа**

ДД	Сумын нэр	Нийт зээлдэгчийн тоо									Үүнээс:			
		2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	Нийт зээлдэгч	Гэрээний хугацаа бүрэн дууссан	Хугацаа дууссан боловч үлдэгдэлтэй	Гэрээний хугацаан даа байгаа	Нийт зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч
1	Алтай сум	2	0	18	10	19	10	14	0	73	45	20	28	48
2	Баян-Уул сум	3	2	20	5	10	18	6	3	67	39	16	28	44
3	Бигэр сум	10	3	20	16	10	14	11	10	94	59	20	35	55
4	Бугат сум	2	3	34	5	8	0	9	4	65	51	28	14	42
5	Дарив сум	2	0	34	2	10	6	4	0	58	45	24	13	37
6	Дэлгэр сум	23	0	28	10	14	2	10	7	94	76	45	18	63
7	Жаргалан сум	11	5	39	1	26	14	21	0	117	76	33	41	74
8	Тайшир сум	13	4	12	8	20	7	12	22	98	57	14	41	55
9	Тонхил сум	1	2	25	9	13	0	19	9	78	50	11	28	39
10	Төгрөг сум	4	0	21	0	8	18	9	6	66	33	14	33	47
11	Халиун сум	14	4	17	12	12	7	9	2	77	62	40	15	55
12	Хөхмөрүт сум	10	0	52	21	5	32	15	10	145	88	51	57	108
13	Цогт сум	1	24	55	6	7	8	12	4	117	93	29	24	53
14	Цээл сум	1	1	12	1	4	0	24	4	47	19	3	28	31
15	Чандмань сум	0	12	21	4	12	9	7	1	66	49	22	17	39
16	Шарга сум	0	18	22	12	14	13	12	4	95	71	25	24	49
17	Эрдэнэ сум	3	1	19	6	13	8	10	6	66	42	4	24	28
18	Есөнбулаг сум	38	20	96	27	28	11	9	11	240	205	141	35	176
Нийт дүн		138	99	545	155	233	177	213	103	1663	1160	540	503	1043

Сангаас зээл авсан 1160 зээлдэгчийн гэрээний хугацаа дууссан боловч 540 нь зээлийн үлдэгдэлтэй байна. Мөн гэрээний хугацаа дуусаагүй 503 зээлдэгч байна.

СХС-ийн зээлийн эргэн төлөлт, авлага барагдуулалтыг сум бүрээр тооцож нийт авлагын үлдэгдэл, гэрээт хугацаанд төлөгдөөгүй зээлийн судалгааг гаргалаа. /Хавсралт-5/


Хүснэгт-6 СХС-ийн зээл эргэн төлөлт, авлагын судалгаа /сая.төгрөг/

Үзүүлэлт	Нийт авлагын дүн	Үүнээс гэрээт хугацаанд төлөгдвөл зохих дүн	Авлагын барагдуулалт					Нийт авлага	Гэрээний үүргээ биелүүлээгүй мөнгөн дүн	
			Төлөгдсөн мөнгөн дүн	Тоног төхөөрөмж буцаан өгсөн	Шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн урамшуулалд	Үүнээс илүү төлөлт			
Гэрээний дагуу эргэн төлөгдөх хуваарь	Төлөгдөх үндсэн зээл	9,050.5	7,306.2	5,454.6	65.4	50.0	0.2	17.7	3,480.2	1,753.7
Бусад орлого	Дуусгавар болсон гэрээний хүлээн зөвшөөрсөн орлого	4.8	4.8	388.3		3.4			113.8	52.0
	үйл ажиллагаа явуулаагүйд тооцсон торгуулийн хүү	11.1	11.1							
Гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцсон торгууль	Нэмэгдүүлсэн хүү	0.1	0.1	82.1					174.4	174.4
	Гэрээт хугацаанд төлөгдөөгүй үндсэн зээлийн үлдэгдэлд тооцсон торгууль	256.5	256.5							
Нийт төлөгдөх дүн		9,812.4	8,006.4	5,925.0	65.4	53.4	0.2	17.7	3,768.4	1,980.1

Дээрх судалгаанаас үзэхэд нийт 9,812.4 сая төгрөгийн авлагаас 5,454.6 сая төгрөгийн үндсэн зээл, 388.3 сая төгрөгийн хүү, 82.1 сая төгрөгийн торгуулийг төлүүлсэн бөгөөд Шүүхийн шийдвэрээр 53.4 сая төгрөгийн үндсэн зээл, хүүгийн орлогыг хүчингүй болгож, 65.4 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийг буцаан өгч, 0.17 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх урамшуулалд тооцуулан аудитаар нийт 3,768.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Сумдын 2018 оны аудитад хамрагдсан хугацаагаар тасалбар болгоход зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 8,006.4 сая төгрөгийг төлүүлсэн байх ёстой байтал 1,753.7 сая төгрөгийн үндсэн зээл, 52.0 сая төгрөгийн хүү, 174.4 сая төгрөгийн торгууль, нийт 1,980.1 сая төгрөгийг гэрээт хугацаанд төлүүлээгүй, гэрээний үүргийг биелүүлээгүй байна. Үүнээс 1,584.3 сая төгрөг нь өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрээс хэрэгжээгүй үлдэгдэл бөгөөд үлдсэн 395.8 сая төгрөг нь 2018 оны хуваарьт хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэл байна. /Хавсралт-6/

Дүрслэл-4 Зээлийн гэрээний дагуу эргэн төлөлт /сая.төг/



Дээрх судалгаанаас сумдыг харьцуулан үзэхэд Бигэр, Тайшир, Тонхил, Цээл, Шарга, Эрдэнэ сумдын тухайд төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл харьцангуй бага төлөх дүнгийн 10, түүнээс доош хувийг эзэлж байхад Алтай, Бугат, Дарив, Дэлгэр, Халиун, Хөхморьт, Цогт, Есенбулаг сумдын төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл харьцангуй их төлөх дүнгийн 25, түүнээс дээш хувийг эзэлж байна.

СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн үндсэн төлбөр, хүү, торгуулийг төлүүлээгүй байгаа нь ажил хариуцсан холбогдох албан тушаалтнууд зээл олголтод хайнга хариуцлагагүй хандсан, эргэн төлүүлэх талаар санаачилгагүй ажилласан, зээлийн ашиглалтын явцад хяналт тавьдаггүйтэй холбоотой байна.

Гэрээт хугацаанд төлөгдөөгүй зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж барагдуулах арга хэмжээ авсан талаар зээлдэгч нэг бүртэй тооцоо хийж нэгтгэсэн судалгаа гаргалаа. /Хавсралт-7/

Хүснэгт-7 **Гэрээний хугацаа хэтэрсэн зээлийн судалгаа** /сая.төгрөг/

ДД	Сумын нэр	Гэрээний хугацаа хэтэрсэн зээлийн		Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй		Гэрээний хугацаа бүрэн дууссан Шүүхэд хандавал зохих		Шүүхээр төлүүлэхээр шийдвэр гаргуулсан		Эвлэрлийн гэрээгээр алдангийг татгалзаж тохирсон мөнгөн дүн	Эвлэрлийн гэрээний хугацаа дуусаагүй		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийлгэх гэрээ байгуулагдса		Шүүхэд өгснөөс хойш төлөгдсөн	Шийдвэр гарсан боловч ШШГА-тай гэрээ байгуулаагүй		Шүүхэд огт хандаагүй, шийдвэр гаргуулаагүй			
		тоо	Төлөгдө өгүй дүн	тоо	Зээлийн дүн	тоо	Зээлийн дүн	тоо	Зээлийн дүн		тоо	Зээлийн дүн	тоо	Зээлийн дүн		тоо	Зээлийн дүн	тоо	Зээлийн дүн	тоо	Зээлийн дүн
		1	Алтай сум	35	103.5	15	16.8	20	86.7		0	-	0	-		0	-	-	0	-	20
2	Баян-Уул сум	37	73.8	21	17.5	16	56.2	2	13.3	0.4	0	-	1	4.6	-	1	8.7	14	43.0		
3	Бигэр сум	42	25.0	22	7.9	20	17.1	3	12.0		1	5.6	-	-	2.4	2	4.0	17	7.5		
4	Бугат сум	35	85.2	7	2.4	28	82.8	9	47.7		2	6.6				7	41.1	19	35.1		
5	Дарив сум	31	89.1	8	8.0	23	81.0	10	69.9		4	53.6			4.5	6	11.8	13	15.6		
6	Дэлгэр сум	60	165.6	15	6.5	45	159.1	6	40.6		0	-			5.6	6	34.9	39	124.2		
7	Жаргалан сум	51	60.6	18	9.5	33	51.1	4	47.2		2	15.3			3.2	2	28.6	29	7.2		
8	Тайшир сум	45	17.7	31	5.1	14	12.6								0	-	14	12.6			
9	Тонхил сум	28	5.1	12	0.6	16	4.5	1	0.3						0.1	1	0.2	15	4.3		
10	Төгрөг сум	21	58.5	8	4.6	13	54.0	8	91.2	-	-	6	32.1	40.0	2	19.0	5	2.8			
11	Халиун сум	55	160.0	15	23.2	40	136.8	0		-	-	0			0	-	40	136.8			
12	Хөхморьт сум	95	106.3	45	39.5	50	66.8	4	23.9			4	13.9	9.9	0	-	46	52.9			
13	Цогт сум	38	125.0	9	12.9	29	112.1	11	31.2		2	6.0			2.7	9	22.4	18	83.7		
14	Цээл сум	8	4.3	5	1.3	3	3.1								0	-	3	3.1			
15	Чандмань сум	34	65.4	12	16.5	22	48.9	13	53.5		8	38.8			9.7	5	5.0	9	5.1		
16	Шарга сум	38	41.0	13	1.5	25	39.4	1	2.8					2.8	0	-	24	39.4			
17	Эрдэнэ сум	16	18.2	12	10.0	4	8.2								0	-	4	8.2			
18	Есенбулаг сум	171	775.8	31	107.4	140	668.4	37	123.9		14	57.5	15	58.3	13.5	8	7.6	103	558.0		
Нийт дүн		840	1,980.1	299	291.2	541	1,688.9	109	557.3	0.4	33	183.5	26	108.9	94.5	49	183.4	432	1,226.1		

Дээрх судалгаанаас үзэхэд нийт 840 зээлдэгчийн гэрээний хугацаа хэтэрсэн 1,980.1 сая төгрөгийн зээлийн авлага байгаагаас 291.2 сая төгрөгийн авлага нь гэрээний хугацаа дуусаагүй 299 зээлдэгчийн, 1,688.9 сая төгрөгийн авлага нь гэрээний хугацаа бүрэн дууссан 541 зээлдэгчтэй холбоотой байна.

Гэрээний хугацаа дууссан 109 зээлдэгчийн 557.3 сая төгрөгийг төлүүлэхээр Шүүхийн шийдвэр гаргуулан 94.5 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ. Үүнээс 33 зээлдэгчийн 183.5 сая төгрөгийн зээлийг төлүүлэх эвлэрлийн гэрээний хугацаа дуусаагүй байна.

Шүүхийн шийдвэрээр төлөхөөр тогтоогдсон 26 зээлдэгчдийн 108.9 сая төгрөгийн төлөгдөөгүй үүргийг албадан гүйцэтгүүлэхээр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэстэй гэрээ байгуулсан бөгөөд үлдэх 49 зээлдэгчийн 183.4 сая төгрөгийн төлөгдөөгүй үүргийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Мөн гэрээний хугацаа дууссан 432 чанаргүй зээлийн 1,226.1 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад шийдвэр гаргуулахаар хандаагүй байна. Тухайлбал Алтай, Тайшир, Халиун, Цээл, Эрдэнэ сумдын хувьд гэрээний хугацаа бүрэн дууссан боловч чанаргүй зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдийн авлагыг хууль хяналтын байгууллагад хандаж авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй байна. /Хавсралт-8/

Гэрээний хугацаа дуусаагүй байгаа зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 291.2 сая төгрөгийн авлагын хувьд сумын Засаг дарга, СХС хариуцсан

мэргэжилтэн нар нь гэрээний 9.2⁹, 9.2.2¹⁰, 9.3¹¹ дахь заалтад заасны дагуу зээлдэгч холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна. Тухайлбал зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцалж зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлэх арга хэмжээг цаг хугацаанд нь авч ажиллах шаардлагатай байна. /Хавсралт-9/

2.2. СХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан уу?


Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.

2.2.1. СХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл сонгон шалгаруулалт журмын дагуу явагдаагүй, чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа хангалтгүй төслийг шалгаруулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөл

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулж байгуулж ажиллахаар журамлагдсан байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг үзэхэд Бугат, Чандмань сум нь банкны төлөөллийг, Бугат, Чандмань, Дарив, Халиун сум нь баялаг бүтээгчдийн холбооны төлөөллийг, Тонхил сум 3 багийн, Халиун, Хөхморьт сум тус бүр 2 багийн төлөөллийг томилоогүй байна. Харин Эрдэнэ сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөөгүй өмнөх Засаг даргаар ахлуулсан байна.



Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгосон байхаар журамд заасан. Гэтэл сумдын зөвлөлийн гишүүдийг сумын ИНХ-аар хэлэлцүүлдэггүй сумын ИТХ-ын тогтоолоор томилсон байна.

Жаргалан, Тайшир, Шарга, Бигэр сумаас бусад сумдын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж баталгаажуулдаггүй байна. СХС-ийн хөрөнгөнөөс 2017, 2018 онуудад зээл авсан иргэний төсөл сонгон шалгаруулалт, гэрээ, бусад баримт бичигтэй танилцаж үзэхэд Бигэр, Тайшир, Халиун, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ сумдын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд, Засаг дарга, СХС хариуцсан нягтлан бодогч нартай холбоотой 18 иргэнд СХС-аас зээл

⁹ Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд гэрээг цуцалж зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ.
¹⁰ Зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн
¹¹ Гэрээний 9.2-т заасан үндэслэлээр Зээлдүүлэгч гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан бол зээлийг төлүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай гэж үзвэл зээлийн барьцааны зүйлийг тухайн үеийн зах зээлийн үнээр борлуулан зээлийн төлбөрийг төлүүлж, сум хөгжүүлэх санд төвлөрүүлэх

олгож, гэрээ байгуулсан байгаа нь Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1¹², Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹³ дэх заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна.

Төсөл сонгон шалгаруулалтын талаар:

ЗГ-ын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” 153 дугаар журмын 3 дугаар зүйлийн 3.3.1-т / сумын ИТХ нь сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлнэ/ гэж заасан. Баян-Уул, Бугат, Жаргалан, Тонхил, Халиун, Есөнбулаг сум 2017, 2018 онуудад, Дэлгэр, Тайшир, Төгрөг, Чандмань сум 2017 онд, Алтай, Дарив, Хөхморьт, Эрдэнэ сумууд 2018 онд сумын ИТХ-ын тогтоолоор нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоогоогүй байна. Баян-Уул сумын СХС-аас 2017 онд Санжин богд хоршоонд зээл олгохдоо сумын ИТХ-ын тогтоолоор баталсан зээлийн дээд хэмжээг 7.5 сая төгрөгөөр хэтрүүлж олгожээ.

СХС-гийн хөрөнгөөр төсөл арга хэмжээний төсөл сонгон шалгаруулалтыг ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу зээл олгох төслийн 6 шалгуур үзүүлэлтийг, зээлдэгчид тавигдах 4 шаардлагын дагуу сонгон шалгаруулалтыг хийхээр заажээ. Дүрслэл-5



Сумууд сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагтаа жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, тэргүүлэх чиглэлээ оновчтой тодорхойлж чадаагүй, сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангаагүйгээс төдийлөн сайн төслийг сонгон шалгаруулж чадахгүй байна.

Төсөл сонгон шалгаруулалтыг 2017, 2018 оныг хамруулан үзэхэд Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоогүй, жижиг дунд үйлдвэрлэл шинээр бий болох боломж байгаа эсэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн эсэх, гэрээний

¹² Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; 4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

¹³ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байгаа эсэх, төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байгаа эсэхийг огт харгалзаж үзэлгүй зөвхөн хурлын тэмдэглэл үйлдэн төсөл сонгон шалгаруулсан байна. Мөн зээл хэлэлцэхээс өмнө зээлийн судалгааг бодит объект дээр нь очиж судалгаа хийдэггүйгээс зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах явдал их байна. /Хавсралт-10/

Сумдын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн ирцийн бүрдэл сонгон шалгаруулалтыг үзлээ. Үүнд:

- ✓ Цээл сум нь 2017 онд 4 иргэнд 11.3 сая төгрөгийн, Алтай сум 2 иргэнд 2.4 сая төгрөгийн, Бигэр сум 3 иргэнд 3.7 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийн зээлийг олгохдоо төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцүүлэлгүй шууд гэрээ байгуулан олгосон.
- ✓ Бигэр сум нь 1 иргэнд авто засварын 4.0 сая төгрөгийн зээлийг төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэргүйгээр шууд олгосон.
- ✓ Халиун сум нь Ч.Пүрэвдорж, Я.Сэсээр нарт 22.0 сая төгрөгийн зээлийг төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэргүйгээр шууд олгосон.

2.2.2. Зээлийн барьцааны гэрээг журмын дагуу байгуулаагүй, гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 72 дугаар тушаалаар СХС-ийн гэрээний загвар тайлан авах маягыг баталсан байна. Аудитаар 2017, 2018 онд зээл авсан иргэдийн баримт материалын бүрдүүлэлтийг үзэхэд дараах асуудлууд байна. Үүнд:

- ✓ Зарим зээл хүсэгчдийн өргөдөл, анкет, оршин суугаа газрын тодорхойлолт, журмын 4.2, 4.3 заасан шаардлагыг хангасныг нотлох баримт байхгүй, зээлийн болон барьцааны гэрээг нотариатаар батлуулаагүй, Тонхил, Шарга, Есөнбулаг сум нь батлагдсан загварын дагуу гэрээ байгуулаагүй.
- ✓ Зээл авсан 312 зээлдэгчийн 233 зээлдэгчдийн барьцааны хөрөнгийн гэрчилгээ эх хувиар байхгүй.
- ✓ Бусдын хөрөнгийг барьцаалсан, хамтран эзэмшигч, өмчлөгчөөс зөвшөөрөл аваагүй байхад 58 зээлдэгчтэй гэрээ байгуулсан.
- ✓ Барьцааны зүйл нь гэрээний үүргийг хангаж чадахааргүй, зах зээлийн үнэлгээг хэт үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн үнэлсэн байна.

ЗГ-ын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” 153 дугаар журмын 3.5.4-т барьцааны гэрээ байгуулахдаа барьцаанд бариулах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэхээр заасан. Аудитаар барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнээс барьцаагаар хангагдах үүргийн дүнг тооцож гэрээ хийсэн дүнтэй харьцуулж үзэхэд 58 зээлдэгчийн барьцааны үүргийн дүнг 183.9 сая төгрөгөөр илүү байгуулсан, барьцаагаар хангагдвал зохих дүнгээс 35 зээлдэгчдэд 83.1 сая төгрөгийн зээлийг илүү олгосон байна.

Мөн Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 72 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн, барьцааны гэрээ байгуулахдаа Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуул, Цагдаа, Татвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Улсын бүртгэл гэх мэт гуравдагч этгээдэд барьцаатай байгаа эсэх талаар лавлагаа аваагүй, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг Улсын бүртгэлд бүртгүүлээгүй, Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөртэй эсэх лавлагаа гаргуулаагүй байна. /Хавсралт-11/

ЗГ-ын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” 153 дугаар журмын 1.7-д “зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана” гэж заасан. Гэвч Чандмань сумаас бусад сумууд зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд алданги тооцох заалтыг огт оруулаагүй гэрээ байгуулсан байна.

Халиун сумын СХС-ийн авлагын хувьд зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч бүрийн гэрээг тулган үзэхэд 59.5 сая төгрөгийн зээл авсан 14 зээлдэгчийн зээлийн гэрээ байхгүй, гэрээнд

засаг дарга гарын үзэг зурж баталгаажуулаагүй, хуудас бүрд зээлдэгчийн гарын үсэг зуруулж нотариатаар баталгаажуулаагүй зөрчилтэй гэрээ нэлээд байна. Аудитаар 2016 оны СТА, 2017 оны СТА-аар зээлдэгчийн гэрээ байхгүй байгаа зөрчилд удаа дараа шийдвэр гаргаж өгч байсан боловч шийдвэрийг огт хэрэгжүүлээгүй байна.

Дэлгэр сумын ахуйн үйлчилгээний төвд ажиллах иргэдэд тоног төхөөрөмжийн зээл олгохдоо 0.5 сая төгрөгийн зөрүүтэй үнээр гэрээ байгуулсанд аудитаар албан шаардлага өгсөн боловч зөрчлийг арилгаагүй.

2.2.3. СХС-ийн зээлийн хэрэгжилт хангалтгүй, жижиг дунд үйлдвэрлэл бий болоогүй ажлын байр нэмэгдээгүй, сумд үр өгөөжөө өгөөгүй, өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэгдсэн байна.

Зээлийн хэрэгжилт, ажлын байр

СХС бий болсон хугацаанаас хойш аймгийн хэмжээнд нийт 1663 иргэн, ААНБ-д зээл олгосон байгаа бөгөөд аудитаар гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үлдэгдэлтэй, гэрээт хугацаандаа байгаа 1043 зээлдэгчийн зээлийг төслийн зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь очиж үзэхийг зорилоо. Гэвч аудитаар нэг сумд 2-3 хоногийн хугацаанд ажилласан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь сумандаа байхгүй, хөдөө малчин, багт амьдардаг зээлдэгчтэй уулзах боломжгүй байлаа.

Аудитаар 3,664.7 сая төгрөгийн 676 зээлдэгч хамрагдаагүй, 1519.8 сая төгрөгийн 216 зээлдэгч нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа эрхэлж, 241.0 сая төгрөгийн 44 зээлдэгчийн үйл ажиллагаа тогтворжоогүй, 569.1 сая төгрөгийн 107 зээлдэгч төслөө хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь зогссон байна.

Төслөөр 1411 ажлын байр бий болгохоор заасан боловч бодит байдал дээр зөвхөн 141 ажлын байр бий болсон байна. Зээлдэгч нарын ихэнх нь гэрээрээ үйл ажиллагаа эрхэлдэг, нийгмийн даатгал төлөгдөөгүй байгаа тул байнгын ажлын байраар хангагдсан гэж үзэх боломжгүй байна. /Хавсралт-12/

Дээрх байдлаас үзэхэд СХС-ийн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгыг үгүйсгэсэн амьжиргааг дэмжих төдий л сангийн хөрөнгө зарцуулагдаж сум орон нутагт үр өгөөжөө өгөхөөргүй болж байна.

Аудитад хамрагдсан зээлдэгчдээс 11 төрийн албан хаагч байна. Аймгийн ИТХ-ын 2013 оны “Санхүүгийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 03 дугаар тогтоолын 2.7 дахь заалтад “Төрийн албан хаагчдад аливаа төсөл, хөтөлбөрийн хөрөнгөнөөс зээл олгодог явдлыг 2014 оноос эхлэн бүрмөсөн таслан зогсоох”-ыг бүх шатны төсөв захирагчид даалгасан байна.

Хөрөнгийн зарцуулалт

СХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг үзэхэд:

- ✓ Есөнбулаг сумын СХС-аас 2012 онд сумын 70 жилийн ойн ном бэлтгэхээр 14.9 сая төгрөгийг тухайн үеийн ЗДТГ-ын даргатай зээлийн гэрээ байгуулан зарцуулсан боловч өдий хүртэл буцаан төлөгдөөгүй, гэрээний дагуу төлөгдөөгүй үүргийн дүнд 6.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан.
- ✓ Халиун сум нь 2014 онд н.Пүрэвврагчаад хээлтүүлэгч мал нийлүүлэх зорилгоор 22.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч 18.0 сая төгрөгийн анхан шатны нотлох баримт байхгүй, хэнд ямар мал өгсөн нь нотлогдохгүй байна.
- ✓ Халиун сум нь 2018 онд хашаажуулах хөтөлбөрийн хүрээнд 21.0 сая төгрөгийн зээлийг СХС-аас гарган, сумын иргэдтэй гэрээ хийн 5272 ширхэг банзыг 29.6 сая төгрөгөөр зээлээр борлуулсан зэрэг СХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.
- ✓ Жаргалан сум нь СХС-аас 2017 онд 3 зээлдэгчид 8.0 сая төгрөгийн зээл өгөхөөр захирамж гарсан байхад үндэслэлгүйгээр 1.6 сая төгрөгийг олгоогүй байна.

Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Жаргалан, Төгрөг, Халиун, Цээл, Чандмань сумдад 2014 онд улсын төсвөөс 152.1 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног

төхөөрөмжийг аймгийн Хөдөлмөрийн хэлтсээр дамжуулан биетээр нь нийлүүлсэн байна. Мөн 2015 онд зээлдэгчийн дансаар дамжуулан оёдлын тоног төхөөрөмжийн зээл олгосон боловч зээлдэгчдээс 65.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг СХС-д буцаан өгсөн байна. Ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжөөс 64.0 сая төгрөгийн төхөөрөмжийг зээлээр олгожээ.

Аудитаар хөрөнгийн тооллого хийхэд Алтай сумд 0.4 сая төгрөгийн, Баян-Уул сумд 5.3 сая төгрөгийн, Дарив сумд 2.2 сая төгрөгийн, Цээл сумд 2.2 сая төгрөгийн, нийт 10.1 сая төгрөгийн 31 нэр төрлийн төхөөрөмж дутагдсан. Үүнээс Алтай сум, Дарив сум нь хөрөнгийг хүнд хүлээлгэн өгсөн боловч зээлийн болон барьцааны гэрээ байгуулаагүй байна. Сумдын нярвын агуулахад 261 ширхэг 143.2 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийг ашиглахгүй үхмэл хөрөнгө болгож байна. /Хавсралт-13/

2.3 СХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнасан уу?

Сумын ИТХ, Засаг даргын үүргийн биелэлт хангалтгүй, орон тооны бус зөвлөлийн хяналт сул, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдаагүй байна.

2.3.1. Сумын ИТХ-ын томилсон орон тооны бус хяналтын зөвлөл, ИТХ нь журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Хяналтын зөвлөл


Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулан, ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулахаар журамлагджээ.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг үзэхэд Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Чандмань, Есөнбулаг сум нь баялаг бүтээгчдийн холбоо, багийн иргэний төлөөллийг томилоогүй байна.

Хяналтын зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгосон байхаар журамд заасан. Гэтэл сумдын зөвлөлийн гишүүдийг сумын ИНХ-аар хэлэлцүүлдэггүй сумын ИТХ-ын тогтоолоор томилсон байна. Сумдын хяналтын зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж баталгаажуулдаггүй байна.

Хяналтын үйл ажиллагаа

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тушаалын “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.1¹⁴, 5.3.2¹⁵ дахь заалтад заасны дагуу хяналтын зөвлөл нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахаар байна.



¹⁴ Зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах

¹⁵ Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх

Гэтэл сумдын хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд улирал тутам хяналт шалгалт хийгээгүй, зарим сум жилд нэг удаа хэдхэн зээлдэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн тэмдэглэл хөтөлсөн, нотлох баримтаар бүрэн дэмжигдээгүй, шалгалтын дүнг сумын нийт иргэдэд мэдээлээгүй, сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна. Мөн зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан гаргуулан аваагүй байна./Хавсралт-14/

Хяналтын зөвлөл журмын дагуу ажиллаагүй, хяналт шалгалт хийсэн тайлан байхгүй, хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, зээлийн үр дүн буурах, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл өсөх, жижиг дунд үйлдвэрлэлд эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

2.3.2. СХС-ийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх бөгөөд сангаас олгосон зээлийн мэдээллийн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах бүрэн эрхтэй байна. Энэ ажил хийгдэх шатандаа явагдаж байгаа бөгөөд Монгол банкны мэдээллийн санд оруулаагүй байна.

СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийн мэдээлэл Монгол банкны мэдээллийн санд орсноор бусад эх үүсвэрээс давхар зээл авсан, найдваргүй зээлдэгчийн судалгаа гарч чанаргүй зээлдэгч нарт дахин зээл олгохгүй байх асуудлыг шийдвэрлэх боломж бий болох тул энэ ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай байна.

Сумдын Засаг дарга нар нь сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж аймгийн Засаг даргад хүргүүлдэг байна.

2.3.3. Сангаас чанаргүй зээл олгосон, хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоо хэрэгжээгүй байна.

Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэдэд дахин зээл олгоогүй байна. Харин чанаргүй зээл олгосон, хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоо хэрэгжээгүй байна.

Сумдын СХС хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч нар нь зээлдэгчтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй, гэрээнд заасан үүргийн дагуу торгууль, алдангийг тооцдоггүй, хяналтын байгууллагаар ажлаа хийлгэж байна.

Цаашид зээлийн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, төслийн зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй, мөн гэрээнд заасан хугацаандаа 1,980.1 сая төгрөгийн зээлийг сангийн дансанд төвлөрүүлээгүй 840 иргэнд дахин зээл олгохгүй байж журмыг мөрдөж ажиллах нь зүйтэй юм. Мөн СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, үр дүнд тавигдах хариуцлагыг шат шатандаа хэрэгжүүлж ажиллахаар байна.

2.4 СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журмын хоорондын нийцэл, бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх, сангийн үйл ажиллагаа нь зорилго зорилтдоо хүрсэн эсэх, цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн асуудал байна уу?

СХС-ийн зээлийг төрийн байгууллагаар дамжуулан олгодог явдлыг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн, хугацаандаа байгаа зээлийг арилжааны банканд шилжүүлэн, цаашид банкаар дамжуулан зээл олгодог болох нь зүйтэй байна.

СХС-ийн зээлийг олгосноор орон нутагт санхүүгийн эрх мэдэл олгогдсон, арилжааны банкаар дамжуулахгүй олгож байгаа нь иргэдэд чирэгдэлгүй, сумын удирдлага жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих идэвх сайжирч, иргэдийн санал санаачилга нэмэгдэх, иргэд бие

биедээ хяналт тавих нөхцөл бүрдэх давуу тал бий болсон хэдий ч зөрчил дутагдал байсаар байна.

Аудитаар СХС-ийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэний оролцоо хэрхэн хангагдаж байгааг дүгнэхээр зорьж иргэдээс санал асуулга авсан. Санал, асуулгын дүнг нэгтгэн дүгнэхэд:

- ✓ СХС-ийн талаар мэдээлэл хангалтгүй, мэдээллийг нутгийн иргэд, орон нутгийн мэдээллийн самбараас авдаг.
- ✓ СХС-ийн талаар холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзээгүй, сургалт явагддаггүй.
- ✓ СХС нь иргэд ААНБ, жижиг дунд бизнес шинээр эхлэх, бизнесээ өргөжүүлэх болон ажлын байр нэмэгдүүлэхэд үр дүнгээ төдийлөн өгөхгүй байна. Зээл авсан иргэд төслөө хэрэгжүүлдэггүй.
- ✓ Сангаас зээл авахад хүндрэл бэрхшээлтэй, хүссэн хэмжээгээр зээл олгодоггүй, танил тал найз нөхөд ах дүүстээ үйлчилдэг, өөрсдөө хувааж авдаг.
- ✓ СХС-ийн үйл ажиллагаа хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь журамд заасан шалгуур үзүүлэлтийг огт харгалзаж үздэггүй, тухайн үед л зээл олгохоос хожим үүсэх үр дагаврыг огт тооцдоггүй, чанаргүй зээлийг сонгон шалгаруулж байна. Орон нутагт СХС-ийн авлага барагдуулах, тайлагнах асуудлыг нягтлан бодогч хариуцаж байгаа бөгөөд СХС-аас гадна ЗДТГ, ИТХ, ОНХС, байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн бүхий л нягтлан бодох бүртгэлийг давхар гүйцэтгэн маш их ачаалалтай ажиллаж байна. Гэтэл төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрээр олгосон чанаргүй зээлийг барагдуулах хариуцлага оногдож, ажлын ачааллын хажуугаар СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг хангуулах ажил хаягдан хугацаа алдаж, найдваргүй зээл бий болж байна. Тухайлбал зээл авсан иргэн зээлийг төлөлгүй, тухайн сум, орон нутгаас шилжээд явсан, хаяг тодорхойгүй болсон, Шүүх хүлээж авах боломжгүй байгаа чанаргүй зээл ихээхэн нэмэгдэн төсвийн хөрөнгө үр ашиггүй үрэгдэж байна.

Иргэдээс авсан санал, аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж үзэхэд СХС-ийн зээлийг төрийн байгууллагаар дамжуулан олгодог явдлыг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн, хугацаандаа байгаа зээлийг арилжааны банканд шилжүүлэн, цаашид банкаар дамжуулан зээл олгодог болох нь зүйтэй байна.

Дэд зорилт-3: Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Аудитаар өгөгдсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1 Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг 45.6 хувиар, албан шаардлагыг 99 хувиар, хариуцлага тооцох саналыг 88 хувиар биелүүлсэн байна.

ОНХС-ийн 2013-2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн, зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна. Бугат сум 36.7 сая төгрөгийн, Дарив сум 1.5 сая төгрөгийн, Хөхморьт сум 26.1 сая төгрөгийн, Цогт сум 6.5 сая төгрөгийн, Аймгийн ОНХС 13.8 сая төгрөгийн актын

үлдэгдэлтэй байна. Аймгийн ОНХС 11.1 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Өмнөх оны СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитын шийдвэрийг 65 хувиар хэрэгжүүлсэн байна.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь СХС-ийн үйл ажиллагаанд 2012 онд гүйцэтгэлийн аудит, 2014 онд нийцлийн аудит, 2014 оноос хойш жил бүр санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийжээ.

Хүснэгт-8 СХС-ийн аудитаар тогтоосон шийдвэрийн хэрэгжилтийн судалгаа /сая.төгрөг/

Аудит хийсэн огноо	Аудитын төрөл	ТОГТООГДСОН АКТ		Нийт тогтоосон акт	Нийт төлүүлсэн дүн	Бодит төлөгдөөгүй актны үлдэгдэл	Шүүхийн шийдвэр гарсан	Статистик мэдээний хэрэгжээгүй шийдвэрийн үлдэгдэл
		Зээлдэгчтэй холбоотой	зориулалт бусаар зарцуулсан					
2012 он	Гүйцэтгэлийн аудит	78.7	-	78.7	72.9	5.8	4.1	1.7
2014 он	Нийцлийн аудит	491.6	6.4	498.0	375.8	122.1	57.1	65.1
2015 он	2014 оны СТА	323.5	6.2	329.8	223.6	106.2	17.7	88.5
2015 он	2015 оны ЗА	229.5	-	229.5	105.0	124.6	31.3	93.3
2016 он	2015 оны СТА	666.0	1.2	667.2	386.2	281.0	119.2	161.8
2017 он	2016 оны СТА	963.4	0.2	963.6	472.8	490.8	103.8	387.0
2018 он	2017 оны СТА	671.2	0.3	671.5	217.7	453.8	56.8	397.0
НИЙТ ДҮН		3,423.9	14.4	3,438.3	1,854.0	1,584.3	390.0	1,194.3

Аудитаар нийт 3,438.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 1,854.0 сая төгрөгийг төлүүлж, 390.0 сая төгрөгийн актад Шүүхийн шийдвэр гаргуулан 1,194.3 сая төгрөгийн хэрэгжээгүй шийдвэрийн үлдэгдэл байна. Шийдвэрийн хэрэгжилтийг сумаар харуулъя.

Хүснэгт-9 Шийдвэрийн хэрэгжилт /сая.төг/

Дүрслэл-6

Аудит хийсэн огноо	Нийт тогтоосон акт	Шийдвэрийн хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	Үлдэгдэл
Алтай сум	161.7	70.6	44%	91.1
Баян-Уул сум	91.8	47.7	52%	44.2
Бигэр сум	59.5	56.3	95%	3.2
Бугат сум	151.3	117.9	78%	33.5
Дарив сум	136.6	128.1	94%	8.6
Дэлгэр сум	216.6	90.5	42%	126.0
Жаргалан сум	162.2	156.1	96%	6.1
Тайшир сум	56.7	56.6	100%	0.1
Тонхил сум	102.5	102.0	100%	0.4
Төгрөг сум	150.3	147.5	98%	2.8
Халиун сум	264.0	123.9	47%	140.0
Хөхморьт сум	166.7	102.0	61%	64.7
Цогт сум	204.5	150.3	73%	54.3
Цээл сум	124.3	122.0	98%	2.3
Чандмань сум	132.8	82.7	62%	50.2
Шарга сум	68.1	61.0	90%	7.0
Эрдэнэ сум	132.1	128.0	97%	4.1
Есөнбулаг сум	1,056.6	500.8	47%	555.8
Нийт дүн	3,438.3	2,243.9	65%	1,194.3



Судалгаанаас үзэхэд аудитын шийдвэрийг Тайшир, Тонхил сум 100 хувь, Бигэр, Дарив, Жаргалан, Төгрөг, Цээл, Шарга, Эрдэнэ сумууд 90-98 хувиар, Бугат, Цогт, 73-78 хувь, Хөхморьт, Чандмань сумууд 61-62 хувь, Баян-Уул сум 52 хувь, Алтай, Дэлгэр, Халиун, Есөнбулаг сум нь 42-47 хувиар хэрэгжүүлсэн байна. Мөн хэрэгжүүлээгүй шийдвэрийн үлдэгдлийн эзлэх хувийг тооцоход Есөнбулаг сум 47 хувь, Халиун сум 12 хувь, Дэлгэр сум 11 хувь, Алтай сум 8 хувь, Хөхморьт, Цогт сум тус бүр 5 хувийг эзэлж байна. /Хавсралт-15/

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад СХС-ийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгах, холбогдох албан тушаалтанд хариуцлага

тооцуулах албан шаардлага хүргүүлсэн. Аудитын шийдвэрийн дагуу дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:

- ✓ СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгах хүртэл тодорхой хугацаанд хөрөнгө захиран зарцуулалт хийхгүй байх
- ✓ Сумын Засаг дарга нарт сануулах арга хэмжээ авах
- ✓ Тухайн сумдын хариуцлагагүй ажилласан төсвийн шууд захирагч нарт арга хэмжээ тооцож ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасан байна.

ИЛРҮҮЛЭЛТ-ОНХС

ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар:

1. Цогт сумын ОНХС-ийн төсвийг батлахдаа орон нутгийн орлогоос үндэслэлгүйгээр 25.5 сая төгрөгийг баталж зарцуулсан.
2. Цээл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 21.3 сая төгрөгийн 6 төрлийн ажлууд нь сумын 2012-2020 оны эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй.
3. Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Халиун, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сум нь иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 32 төсөл арга хэмжээнд 369.8 сая төгрөгийн төсвийг сумын ИТХ-аар баталсан.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 3,167.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 117 ажлыг ИТХ-аар баталсан.

ОНХС-ийн хөрөнгийн гүйцэтгэлийн талаар

5. ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр 147.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 ажлыг шууд гэрээ байгуулсан.
6. Дэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх өөрөө буулгагч хог тээврийн машин нийлүүлэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулан "Хөв дэлгэр" хоршоог шалгаруулсан байтал "Эй Ди Өү" ХХК-тай 15.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.
7. ОНХС-ийн зааварт нийцээгүй 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 541.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
8. Төгрөг, Халиун, Есөнбулаг сум нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын батлагдсан төсвийг 4.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
9. Халиун, Цээл, Шарга, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 267.7 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан боловч төсөл хэрэгжүүлэгч хүлээлгэж өгөөгүй.
10. ОНХС-аас хэрэгжүүлсэн 207.7 сая төгрөгийн өртөг бүхий 38 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй.
11. Хөхморьт сумын ЗДТГ-ын агуулахад их хэмжээний задарсан өвсний үлдэгдэл байгаа бөгөөд өвс борлуулах ажилд хяналт тавьж ажиллаагүй байна.
12. Халиун, Цогт, Чандмань, Есөнбулаг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 64.5 сая төгрөгийн 14 ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан баримт материал байхгүй.
13. Алтай сумын 3.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Соёлын төвийн барилгын дээврийн засварын ажил хангалгүй хийсэн, Цогт сумын соёл амралтын талбайн хайсны суурь, явган зам спортын талбайн тохижилтын ажлыг дутуу гүйцэтгэсэн байхад хүлээж авсан.
14. ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний баримт материалтай танилцахад Халиун сумын гамшгаас хамгаалах ажлын шатахуунд зарцуулсан 1.0 сая төгрөгийн, Чандмань сумын 5.0 сая төгрөгийн баяр наадмын зардлын, Эрдэнэ сумын айл өрхийн хог тээвэрт зарцуулсан 4.7 сая төгрөгийн анхан шатны баримт материал байхгүй.
15. Цогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 68.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 ажлын тухайд гүйцэтгэгчийн хийсэн ажлын тайлан гаргаж өгөөгүй, анхан шатны нотлох баримтгүй байхад санхүүжилтийг олгосон.

16. ОНХС-ийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор бэлтгэсэн өвс тэжээлийг бүртгэл тайланд тусгахгүйгээр данснаас гадуур хөтөлж 55.2 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
17. Тонхил сум нь "Өндөр Индэр" хоршоотой байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад 4.0 сая төгрөгийн өвс тэжээлийн мөнгийг төлүүлээгүй бөгөөд гэрээний дагуу 2.0 сая төгрөгийн алданги нэмж ногдуулсан.
18. Малчидтай хийсэн гэрээний хугацаа дууссан байхад 448.4 сая төгрөгийн малыг хүлээж аваагүй.
19. "Их очирт наран" ХХК-тай 2016 онд сумын 0.4 шугамын өргөтгөлийн ажил хийлгэхээр гэрээ байгуулж 7.0 сая төгрөг шилжүүлсэн боловч одоог хүртэл ажил эхлээгүй бөгөөд уг асуудлыг хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлэх талаар ажиллаагүй байна.
20. ОНХС-гаар хийгдсэн 104.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.
21. Тонхил сумын ЭМТ-д бэлтгэсэн 12.0 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг ЗДТГ-ын данс бүртгэлд орлого авсан.

Сангийн хөрөнгөөр зарцуулалтын хяналтын талаар:

22. ИТХ-ийн дэргэдэх Хяналтын хорооноос хэрэгжсэн төсөл хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

ИЛРҮҮЛЭЛТ: СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН

СХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар:

1. Сумдын ИТХ-аар баталсан СХС-ийн хөрөнгийн төсөв нь орон нутгийн нэгдсэн төсвийн СХС-ийн төлөвлөлтөөс 2017 онд 240.7 сая төгрөгөөр, 2018 онд 456.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
2. СХС-ийн зээлийн зээлийн эргэн төлөлтийн төсвийг төлөвлөхдөө өмнөх оны үндсэн зээл, хүү, торгууль алдангийн төлөгдөөгүй үлдэгдлийг тооцолгүй 2017 онд 1,987.2 сая төгрөгийн, 2018 онд 2,975.5 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг дутуу төлөвлөсөн.
3. Зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад зарцуулах төсвийн дүнг 2017 онд 3.9 сая төгрөгөөр, 2018 онд 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй, хяналтын зардлын дүнг 2017 онд 12.7 сая төгрөгөөр зөрүүтэй төлөвлөсөн.
4. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих зардлын төсөв батлаагүй байхад 2018 онд 0.8 сая төгрөгийг зарцуулсан.

Зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү торгуулийг бүрэн төвлөрүүлсэн талаар

5. Гэрээт хугацаанд сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээр 343.3 сая төгрөгийн үндсэн зээл, 11.2 сая төгрөгийн хүүг төлүүлээгүй байна.
6. Гэрээний дагуу үндсэн зээлээ төлөөгүй иргэдэд нэмж 39.2 сая төгрөгийн торгууль ногдууллаа.
7. Өмнөх аудитын шийдвэрээс иргэдээр төлүүлэх 1,584.3 сая төгрөгийн төлбөрийн актыг төлүүлээгүй.
8. Шүүхийн шийдвэрээр төлөхөөр тогтоогдсон 49 зээлдэгчийн 183.4 сая төгрөгийн төлөгдөөгүй үүргийг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэстэй гэрээ хийж барагдуулах арга хэмжээ аваагүй байна.
9. Гэрээний хугацаа дууссан 432 зээлдэгчийн 1,226.1 сая төгрөгийн чанаргүй зээлийг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулалтын талаар:

10. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг үзэхэд Бугат, Чандмань сум нь банкны төлөөллийг, Бугат, Чандмань, Дарив, Халиун сум нь баялаг бүтээгчдийн холбооны төлөөллийг, Тонхил сум 3 багийн, Халиун, Хөхморьт сум тус бүр 2 багийн төлөөллийг томилоогүй байна. Харин Эрдэнэ сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөөгүй өмнөх Засаг даргаар ахлуулсан байна.

11. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцүүлээгүй шууд томилсон.
12. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж баталгаажуулаагүй.
13. СХС-ийн хөрөнгөнөөс 2017, 2018 онуудад зээл авсан иргэний төсөл сонгон шалгаруулалт, гэрээ, бусад баримт бичигтэй танилцаж үзэхэд Бигэр, Тайшир, Халиун, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ сумдын Засаг дарга, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд, СХС хариуцсан нягтлан бодогч нартай холбоотой 18 иргэнд СХС-аас зээл олгож, гэрээ байгуулсан.
14. Баян-Уул, Бугат, Жаргалан, Тонхил, Халиун, Есөнбулаг сум 2017, 2018 онуудад, Дэлгэр, Тайшир, Төгрөг, Чандмань сум 2017 онд, Алтай, Дарив, Хөхморьт, Эрдэнэ сумууд 2018 онд сумын ИТХ-ын тогтоолоор нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоогоогүй.
15. Баян-Уул сумын СХС-аас 2017 онд Санжин богд хоршоонд зээл олгохдоо сумын ИТХ-ын тогтоолоор баталсан зээлийн дээд хэмжээг 7.5 сая төгрөгөөр хэтрүүлж олгожээ.
16. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь зээл авч төсөл хэрэгжүүлэх иргэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага, зээл олгосон төслийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг хянаж үзэлгүйгээр зөвхөн хурлын тэмдэглэл үйлдэн төсөл сонгон шалгаруулсан.
17. СХС-ийн хөрөнгөнөөс төсөл сонгон шалгаруулах хурлаар хэлэлцүүлэлгүй 11 иргэнд 43.4 сая төгрөгийн зээл олгосон.

Зээлийн гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрээний загварыг мөрдөж байгаа талаар

18. Зээл авсан иргэдийн баримт материалын бүрдүүлэлтийг үзэхэд зарим зээл хүсэгчдийн өргөдөл, анкет, оршин суугаа газрын тодорхойлолт, журмын 4.2, 4.3 заасан шаардлагыг хангасныг нотлох баримт байхгүй, зээлийн болон барьцааны гэрээг нотариатаар батлуулаагүй, Тонхил, Шарга, Есөнбулаг сум нь батлагдсан загварын дагуу гэрээ байгуулаагүй байна.
19. Сумууд зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд алданги тооцох заалтыг огт оруулаагүй гэрээ байгуулсан.
20. Зээл авсан иргэдийн барьцаалсан хөрөнгийн гэрчилгээ 312 зээлдэгчийн хүрээнд үзэхэд 233 зээлдэгчдийн барьцааны хөрөнгийн гэрчилгээ эх хувиар байхгүй байна.
21. Бусдын хөрөнгийг барьцаалсан, хамтран эзэмшигч, өмчлөгчөөс зөвшөөрөл аваагүй байхад 58 зээлдэгчтэй гэрээ байгуулсан.
22. Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнээс барьцаагаар хангагдах үүргийн дүнг тооцож гэрээ хийсэн дүнтэй харьцуулж үзэхэд 58 зээлдэгчийн барьцааны үүргийн дүнг 183.9 сая төгрөгөөр илүү байгуулсан, барьцаагаар хангагдвал зохих дүнгээс 35 зээлдэгчдэд 83.1 сая төгрөгийн зээлийг илүү олгосон.
23. Зээлийн барьцааны гэрээ байгуулахдаа Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуул, Цагдаа, Татвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Улсын бүртгэл гэх мэт гуравдагч этгээдэд барьцаатай байгаа эсэх талаар лавлагаа аваагүй, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг Улсын бүртгэлд бүртгүүлээгүй, Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөртэй эсэх лавлагаа гаргуулаагүй байна.
24. Халиун сумын СХС-аас 59.5 сая төгрөгийн зээл авсан 14 зээлдэгчийн зээлийн гэрээ байхгүй, 46.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
25. Дэлгэр сумын ахуйн үйлчилгээний төвд ажиллах иргэдэд тоног төхөөрөмжийн зээл олгохдоо 0.5 сая төгрөгийн зөрүүтэй үнээр гэрээ байгуулсанд аудитаар албан шаардлага өгсөн боловч зөрчлийг арилгаагүй.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн хэрэгжилтийн талаар

26. Аудитаар 3,664.7 сая төгрөгийн 676 зээлдэгч хамрагдаагүй, 241.0 сая төгрөгийн 44 зээлдэгчийн үйл ажиллагаа тогтворжоогүй, 569.1 сая төгрөгийн 107 зээлдэгч төслөө хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь зогссон байна.
27. Бодитой бий болсон ажлын байр байхгүй, нийгмийн даатгал, ХХОАТ төлөөгүй, Татварын байцаагч СХС-ийн зээл авсан иргэдээс ХХОАТ авдаггүй байна.
28. Есөнбулаг сумын СХС-аас 2012 онд сумын 70 жилийн ойн ном бэлтгэхээр 14.9 сая төгрөгийг тухайн үеийн ЗДТГ-ын даргатай зээлийн гэрээ байгуулан зарцуулсан боловч буцаан төлөгдөөгүй, нэмж 6.9 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.
29. Халиун сум нь 2014 онд н.Пүрэврагчаад хээлтүүлэгч мал нийлүүлэх зорилгоор 22.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч 18.0 сая төгрөгийн анхан шатны нотлох баримт байхгүй, хэнд ямар мал өгсөн нь нотлогдохгүй байна.
30. Халиун сум нь 2018 онд хашаажуулах хөтөлбөрийн хүрээнд 21.0 сая төгрөгийн зээлийг СХС-аас гарган, сумын иргэдтэй гэрээ хийн 5272 ширхэг банзыг 29.6 сая төгрөгөөр зээлээр борлуулсан.
31. Жаргалан сум нь СХС-аас 2017 онд 3 зээлдэгчид 8.0 сая төгрөгийн зээл өгөхөөр захирамж гарсан байхад үндэслэлгүйгээр 1.6 сая төгрөгийг олгоогүй байна.
32. Аудитаар хөрөнгийн тооллого хийхэд Алтай сумд 0.4 сая төгрөгийн, Баян-Уул сумд 5.3 сая төгрөгийн, Дарив сумд 2.2 сая төгрөгийн, Цээл сумд 2.2 сая төгрөгийн, нийт 10.1 сая төгрөгийн 30 нэр төрлийн төхөөрөмж дутагдсан.
33. Сумдын агуулахад ашиглалтгүй 261 ширхэг 143.2 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмж байна.

Сангийн хөрөнгөөр зарцуулалтын хяналтын талаар:

34. Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Чандмань, Есөнбулаг сум нь хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд баялаг бүтээгчдийн холбоо, багийн иргэний төлөөллийг томилоогүй.
35. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцүүлээгүй шууд томилсон.
36. Хяналтын зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж баталгаажуулдаггүй байна.
37. Сангийн үйл ажиллагаанд хяналтын зөвлөл улирал тутам хяналт хийгээгүй шалгалтын дүнг сумын нийт иргэдэд мэдээлээгүй, сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй, зээлдэгчдээс үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан гаргуулаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, илрүүлэлт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

- ОНХС-ийн орлогыг төлөвлөх, гүйцэтгэлийг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хууль, орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг баримталж ажиллаагүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ иргэд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар хууль, журамд заасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, иргэдийн хяналт хийгдээгүй.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, тайлан мэдээг сумууд ирүүлээгүй, хэлэлцээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

- СХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад эдийн засгийн тооцоо, судалгаа, үндэслэл муутай, чанаргүй төсөл шалгаруулж байгаа нь сангийн

хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шалтгаан болж байгаа төдийгүй найдваргүй авлага бий болох суурийг болж байна.

- Сумын ИТХ, Засаг даргын үүргийн биелэлт хангалтгүй, орон тооны бус зөвлөлийн хяналт сул, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдаагүй байна.
- СХС-ийн зээлийг төрийн байгууллагаар дамжуулан олгодог явдлыг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн, хугацаандаа байгаа зээлийг арилжааны банканд шилжүүлэн, цаашид банкаар дамжуулан зээл олгодог болох нь зүйтэй байна.

Ерөнхий Дүгнэлт

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТАД МӨРДӨХ ХУУЛЬ, ЖУРАМ, ЗААВРЫН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Зөвлөмж

ОНХС-ийн чиглэлээр

Сумын ИТХ-ын дарга нарт:

1. Сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй, иргэдээс санал аваагүй, эрэмбэлээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоогүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлахгүй байх
2. ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэн, зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллах

СХС-ийн чиглэлээр

Сумдын Засаг дарга нарт:

1. Сангийн хөрөнгийг бодит тооцоонд үндэслэн хууль, журамд заасны дагуу төлөвлөж гүйцэтгэлийг хангах

Албан шаардлага

ОНХС-ийн чиглэлээр

Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт:

2. Сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй, иргэдээс санал аваагүй, эрэмбэлээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоогүй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхгүй байх
3. ОНХС-ийн зарцуулалтад мөрдөх хууль, журам, зааврыг мөрдөж илэрсэн зөрчлийг арилган, сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн үр ашиг, үр дүнг сайжруулах
4. Малжуулалтын гэрээний хугацаа дууссан иргэдээс малыг хүлээн авч дараагийн иргэнийг малжуулах
5. Бүртгэлд тусгаагүй хөрөнгийг холбогдох байгууллагын дансанд орлого авах

СХС-ийн чиглэлээр

ТЕЗ, аймгийн Засаг дарга С.Гансэлэмд:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийг эргэн төлөх хугацаа хэтэрсэн, үйл ажиллагаа явуулаагүй зэрэг чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэн, чанаргүй төсөл сонгон шалгаруулсан, тэдгээрт зохих хяналт тавиагүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулах

2. Ашиглагдахгүй байгаа ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийг хэрэгцээтэй байгаа иргэн, ААНБ-тай гэрээ хийж, борлуулах ажлыг зохион байгуулах

Сумдын Засаг дарга нарт:

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилган, сангийн хөрөнгийн ашиглалт, зээл төлөлтөд хяналт тавьж, төсвийг зохистой удирдан, гэрээт хугацаанд авлагыг төлүүлэх арга хэмжээ авч ажиллах
2. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг чанд мөрдөж ажиллан, үүрэг хариуцлагыг сайжруулж биелэлтийг хангуулах
3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах
4. Ашиглагдахгүй байгаа ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийг хэрэгцээтэй байгаа иргэн, ААНБ-тай гэрээ хийж, борлуулах ажлыг зохион байгуулах

Төлбөрийн акт

СХС-ийн чиглэлээр

Сумдын Засаг дарга нарт:

1. Гэрээнд заасан хугацаанд барагдуулаагүй үндсэн зээл, хүү болох 354.5 сая төгрөг, хугацаандаа төлөгдөөгүй үндсэн зээлийн торгууль, алданги болох 39.2 сая төгрөгийг төлүүлж сумын СХС-ийн дансанд төвлөрүүлэх
2. Тооллогоор дутагдсан 10.1 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмжийн шалтгааныг тодруулан төсвийг хохиролгүй болгох

Халиун сумын Засаг дарга Т.Алтансүхт:

3. Хашаажуулах хөтөлбөрийн хүрээнд сангийн хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулан иргэдэд зарсан 29.6 сая төгрөгийн банзны үнийг төлүүлж СХС-ийн дансанд төвлөрүүлэх.

Жаргалан сумын Засаг дарга Д.Баярсайханд:

4. Зээлийн гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэгчдэд 1.6 сая төгрөгийн санхүүжилтийг нөхөн олгох

ОНХС-ийн чиглэлээр

Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт:

1. Сангийн хөрөнгөөр бэлтгэн борлуулсан өвс тэжээлийн үнэ болох 61.7 сая төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх.

Жаргалан сумын Засаг дарга Д.Баярсайханд:

2. "Их очирт наран" ХХК-ийн гүйцэтгээгүй ажилд олгосон санхүүжилт болох 7.0 сая төгрөгийг төлүүлж ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх

Уламжлах нь

УАГ-ын газарт:

1. “СХС-ийн зээлийг төрийн байгууллагаар дамжуулан олгодог явдлыг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэн, хугацаандаа байгаа зээлийг арилжааны банканд шилжүүлэн, цаашид банкаар дамжуулан зээл олгодог болгох” асуудлыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал

